

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА

УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ДАРГА
Ц.ТӨМӨР-ОЧИР



ТӨРИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ГАДААДАД СУРАЛЦАГЧТАЙ
БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

20.11.оны 11-р сарын 21-ны өдөр

№...

Улаанбаатар хот

2017 1 1 22 1 3 9

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төвийг төлөөлж Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн албаны дарга З.Наранбаатар /цаашид ЭМАХА гэх/ нөгөө талаас төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал Шүтгэ овогтой Шүтгэ төв эмнэлэг/тусгай мэргэжлийн

албан тушаалтай Ашигсарагийн онцлогоо ажлын төсөл эмч/сувилагч/эмнэлгийн бусад мэргэжилтэн ажилтай Нурэвнэв овогтой Амармарга /цаашид суралцагч БНСУ гэх/ улсын Бонеси нар нь на сургуулийн зурвчийг хэв агаар эмнэлэг/сургуульд

хуног/-ийн хугацаатайгаар сургалтад /дэмжих сан/ төрийн санхүүжилтээр/ суралцуулахаар харилцан тохиролцож байгуулав.

1.2. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2017 - 2020 оны тэргүүлэх чиглэл, 2017 оны гадаад сургалтын төлөвлөгөө батлах тухай" А/312, Эрүүл мэндийн сайдын 2014 оны "Журам батлах тухай" 119 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам", Эрүүл мэндийн сайдын 2017 оны сургалтын хяналтын тоо, зардал батлах тухай" А/188, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2017 оны "Сургалтын зардал батлах тухай" А/187 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор харилцан тохиролцож гэрээ байгуулав.

1.3. Гэрээг 3% үйлдэж ЭМХТ, суралцуулагч байгууллага, суралцагч тус бүр 1%-г хадгалах ба 2017 оны 11-р сарын 21-с 12 оны 12-р сарын 17-ны өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

2.1. Эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтнийг эрүүл мэндийг дэмжих сан болон төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах төлөвлөгөө нь эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхжуулах замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Энэхүү гэрээгээр Сургалтыг зохион байгуулагч, Ажил олгогч буюу захиалагч байгууллага, Суралцагчийн эрх, үүрэг, хариуцлагатай холбогдсон асуудлыг зохицуулна.

2.3. "Сургалт" нь 2017 оны 12-р сарын 03-ны өдрөөс 2017 оны 12-р сарын 17-ны өдрийг хүртэл хугацаанд үргэлжилнэ.

2.4. Тухайн байгууллагад шаардлагатай мэргэжлээр бэлтгэгдсэн суралцагч нь эзэмшсэн, дээшлүүлсэн мэргэжлээрээ “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам”-ын дагуу тогтвор суурьшилтай ажиллана.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Төгсөлтийн дараах сургалтад сурахаар сонгогдсон эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтнийг тогтоосон хугацаанд тухайн орны сургалтын байгууллагад суралцах боломжоор хангаж, гэрээ байгуулан сургалтад явуулах ажлыг зохион байгуулна.

3.2. Суралцагчдад суралцах хугацаанд хэрхэн суралцах талаар заавар, зөвлөгөө өгч, мэдээллээр хангана.

3.3. Суралцагчдын зам хоног /хоол/, хот доторх унааны мөнгө, замын зардлыг зохих журмын дагуу олгоно.

3.4. Суралцагчийн сургалтын чанарт хяналт хийн, гарсан зөрчил дутагдлыг арилгуулахаар шаардлага тавина.

ДӨРӨВ. СУРАЛЦАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Суралцах байгууллагад тогтоосон хугацаанд очиж суралцана.

4.2. Суралцаж байх хугацаандаа тухайн сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу идэвхтэй суралцаж, хангалттай үнэлгээтэй гэрчилгээтэй төгсөнө.

4.3. Сургалтын хөтөлбөрийн дагуу сурч чадаагүй, хүндэтгэн үзэх шалтгаанаар сургалтыг орхих тохиолдолд ЭМХТ-д албан ёсоор 10-14 хоногийн өмнө мэдэгдэнэ.

4.4. Гадаадын өндөр хөгжилтэй оронд сурах, виз авах, явахад шаардагдах бичиг баримтыг шаардсан хугацаанд гаргаж өгнө.

4.5. Сургалт эрхлэгч байгууллагаас явуулж буй сургалтын үйл явц, хөтөлбөртэй холбоотой санал хүсэлт, гомдлыг тухайн эрүүл мэндийн байгууллагад гаргана.

4.6. Гэрээний биелэлтийн талаар саналаа илэрхийлэх, шаардлага тавина.

4.7. Суралцах хугацаандаа тухайн улс орны хууль, тогтоомж, ёс заншил, болон суралцагч байгууллагын дэг журам, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чанд сахиж идэвх чармайлттай суралцана.

4.8. Сургалтын хөтөлбөрөөр олж авсан мэдлэг туршлагаа өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэн, шинийг санаачлагч, манлайлагч байж хамтран ажиллагсдадаа эдгээр олж авсан ур чадвараасаа хуваалцан, ажлын байран дах сургалт зохион байгуулж, зөвлөмж өгөн ажиллана.

4.9. Сургалтын явцын тайланг сургалт эхэлснээс хойш 7 хоногт багтаан , төгсөж ирээд төгсөлтийн тайланг 7 хоногийн дотор, үр дүнгийн тайланг 3 дахь сард, 6 дахь сард тус тус ЭМХТ-д бичгээр гаргаж өгнө.

ТАВ. ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Төрийн сангийн зардлаар суралцагч нь “Сургалт”-аа дүүргэн эх нутагтаа буцаж ирсний дараа ажлын байраар хангаж, мэргэжил ур чадварыг үр дүнтэй ашиглана.

5.2. Суралцах хугацаанд нь ажлын байр, орон тоог хадгална.

5.3. Суралцах хугацааны цалинг олгоно.

5.4. Гадаадын өндөр хөгжилтэй оронд сурах, виз авах, явахад шаардагдах бичиг баримтыг шаардсан хугацаанд гаргаж өгнө.

5.5. Суралцагчийг сургалтын хөтөлбөр, сургалтын өмнөх бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

5.6. Товлосон хугацаанд сургалтад хамрагдаж, сургалтын хөтөлбөрийг хангаж, суралцаж буй эсэхэд хяналт тавина.

5.7. Төрийн сангийн зардлаар суралцагч төгсөөд эзэмшсэн мэргэжлийн дагуу ажиллаж буй эсэхэд хяналт тавина.

5.8. Суралцагчийн байгууллагадаа оруулж буй хувь нэмэрт үнэлгээ хийж ЭМХТ-д тайланг жил бүр хүргүүлнэ.

5.9. Суралцагчийн сургалтын түвшин, нөхцөл байдлын талаар гадаадын эрүүл мэндийн байгууллагаас мэдээлэл авна.

ЗУРГАА. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1. Талуудын хүлээх хариуцлагыг Эрүүл мэндийн сайдын 2014 оны "Журам батлах тухай" 119 дүгээр тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журмын дагуу зохицуулна

ДОЛОО . БУСАД

7.1. Талууд гэрээнд заасан эрх, үүргээ чанд сахин биелүүлнэ.

7.2. Талууд харилцан тохиролцож бичгээр энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд зөвхөн бичгээр үйлдсэн гэрээний нэмэлт өөрчлөлтийг хүчинтэйд тооцон энэхүү гэрээний салшгүй хэсэг болгон баталгаажуулна.

НАЙМ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

8.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан аливаа маргааныг 3 тал харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд талууд үл ойлголцолд хүрвэл маргааныг шүүхийн байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ
ХӨГЖЛИЙН АЛБАНЫ ДАРГА
Зориг овогтой Наранбаатар

(гарын үсэг)

ЗАХИАЛАГЧ ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,
СУРГАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА
ЭРХЭЛСЭН ОРЛОГЧ ДАРГА

О.БАТГЭРЭЛ

(гарын үсэг)

СУРАЛЦАГЧ:

Улаанбаатар аймаг/ нийслэлийн ШУГТ эмнэлгийн

Пурэвжав Сүхсэв ажилтай
П. Нэг овогтой Ариетмаа
(гарын үсэг) (РД: ЧОБЖБДЧБ, Утас: 88 987 906)

2017 оны -р сарын - ны өдөр.